



Үүсгэн байгуулагчийн бодрол

Бүх зүйл бусдын ач буян

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 183 (2020.12)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Энэ жил ч гэсэн эрүүл энх нэгэн жилийг үдэж байна гээд бодохоор “Маш их ач буяныг хүртэж дээ” хэмээн сэтгэлийн гүнээс бодогдож байна.

“Үндэс, навчныхаа ачаар багваахай цэцэг дэлбээллээ” гэсэн хэн нэгний шүлгийн бадаг байдаг. Бид багваахай цэцгийн өнгө үзэмжид л анхаарлаа хандуулахаас биш үндэс, навчныхаа ачаар цэцэглэдэг гэдгийг анзаарахгүй нь олон. Түүнтэй адил бид нөхрийнхөө ачаар, эхнэрийнхээ ачаар, эцэг эхийнхээ ачаар, хүүхдийнхээ ачаар, эргэн тойрны хүмүүсийн ачаар бүх зүйл болж бүтэж байгааг мэдээжийн зүйл мэтээр бодож, анзаарахгүй өнгөрдөг биш гэж үү. Сэтгэлийнхээ мэлмийг сайн нээхгүй л бол энэ хорвоогийн хамгийн чухал зүйлүүдийг олж харж чадахгүй.

107 насалсан Киомизү хийдийн мастер Оониши Рёокэи багш “Талархсанаа илэрхийлж амьдрах ямар сайхан гээч.” гэсэн байдаг.

Жилийн төгсгөлд ойр тойрныхоо хүмүүсийн ач тусыг дахиад нэг эргэн хараарай хэмээн хүсэж байна.

«Үүсгэн байгуулагчийн үг» 9



Ерөнхийлөгчийн айлдвар

Өдөр бүрийг өөдрөг, шинэлэг өнгөрүүлэх

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Энэ газар бол номын өргөө”

Энэ жил шинэ төрлийн корона вирус цар тахлын улмаас хэн хүнгүй өнөөг хүртэлх амьдралын хэв маягаа өөрчлөхөөс өөр аргагүй байдалд хүрсэн нэг жил байлаа.

Та бүхний дотор вирусын халдвар авсан эсвэл ойр дотны хүнээ алдсан хүн байгаа байх. Тэдгээр олон хүмүүсийн бие сэтгэлийн зовиур, энэ өвчнөөс айх айдас нэг өдрийн өмнө ч болов алга болохыг хүсэн залбирч буй хүн ганц би биш биз ээ.

Гэхдээ амьдралын хэв маяг яаж ч өөрчлөгдсөн мартаж үл болох зүйл бий.

“Цагаан Лянхуа Сударт итгэн сүсэглэгч хүний амьдарч буй газар бүхэн номын өргөө байдаг.”, “Цагаан Лянхуа Судраар бол бидний өдөр тутмын амьдрал өөрөө бурханы зам мөрд хичээх үйл юм.” (Күбота Шёобүн багш) гэсэн байдаг.

Корона вирусын улмаас сэтгэл зовнил хийгээд айдас түгшүүртэй байгаа хэдий ч дээрх сургаалын дагуу бусдыг энэрэн хайрлах сэтгэлээ маргалгүй бие биетэйгээ харилцаж бурхны үйлийг хэрэгжүүлсэн байх гэж бодож байна. Японд “өөрийгөө тусгаарлах” гэдэг үг гарснаар “өөрийгөө тусгаарлаж буйг хянах цагдаа” гэсэн үг хэллэг ч гарлаа. Энэ нь жинхэнэ цагдаа биш ба өөрийгөө тусгаарлахгүй, коронагийн үеийн журмыг дагахгүй байгаа хүмүүсийн эсрэг янз бүрийн дайрч давшилсан үйлдэл хийх хувь хүмүүсийг хэлж буй юм. Харин та бүгд өөрөөсөө өөр санаа бодолтой хүний байр байдлыг ойлгож, эелдэг, уян хатнаар хүлээн авч чадсан уу? Байгаа газар бүхэн тэр чигээрээ номын өргөө болохоор өдөр бүрийн үйл явдал нэг бүр нь бурханы зам мөрд хичээх боломж юм.

Сэтгэл санаа ариуссанаар

Цагаан Лянхуа Судрын “Ном номлогчийн эрдэм буяныг өгүүлэх бүлэг”-т амьдралын хэв маяг хийгээд өдөр бүрийн үг үйлдлээрээ дамжуулж судрын сургаалыг хэрэгжүүлэн, ертөнцөд түгээгч хүний зургаан эрхтэн (нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл) цэвэр ариун болдог гэсэн байдаг.

Ерөнхийлөгчийн айлдвар

“Зургаан эрхтэн цэвэр ариун болох” гэхээр Японд энэ үгийг уншиж дуудангаа ууланд авирдаг ёс санаанд орж байна. Цэвэр агаар, байгалийн сайханд ууланд авирахаар ямар ч хүний бие, сэтгэл ариусдаг. Уулын өөрийнх нь гайхамшигтай бурханлаг уур амьсгал хийгээд ууланд орших бурхан сахиусны нөлөөгөөр таван мэдрэхүй ариусч, өөрийн төрөлх сэвгүй ариун сэтгэлийг эргүүлэн олж авдаг байж мэдэх юм.

Гэвч бид ууланд авирахгүй байсан ч цэвэр ариун, уужуу тайван сэтгэлээр аливааг хүлээн авч, өдөр бүрийг өөдрөг, шинэлэгээр өнгөрүүлэх аргыг мэдэх билээ. Түүний нэг бол “Энэ газар бол номын өргөө” гэдгийг хэрэгжүүлэх юм.

Бусдын сайн тал харагдаж, мууг нь хайх сэтгэл төрөхгүй байх. Юу ч байсан амтархан идэх. Судрыг уншиж, бусадтайгаа хуваалцах нь хэвшил болж, хүнтэй уулзахаараа өөрийн эрхгүй алга хавсран мөргөдөг болох. Та ийм байж чадаж байгаа бол цэвэр тунгалаг сэтгэлээр амар амгалан өдрүүдийг өнгөрүүлж байна гэж хэлж болох болов уу.

Ачлалт багш Сакамото Юкио гуай “Бидний өдөр тутмын амьдрал өөрөө тэр чигээрээ бурханы зам мөрд хичээх үйл байдаг бөгөөд Бурханы хамаг амьтаныг аварч нигүүлсэх үйл явц байдаг.” гэж хэлсэн байдаг.

Тэгвэл бид бүхэн өдөр бүр бурханы зам мөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ аврагдаж байдаг ба сэтгэл санаа тавгүйтэх зүйлгүй жинхэнэ аз жаргалыг үргэлж амталж байдаг гэсэн үг юм.

“Цагаан Лянхуа Судрыг баригч хүмүүн бээр сэтгэлийн эрхтний ариун нь энэ мэт больюу. Хэдүй цувралгүйг олоогүй хэмээвч эн тэргүүнд энэ мэт бэлгэт больюу. Энэ хүмүүн бээр энэхүү судрыг барьснаар ариун нандин газарт амгалан сууж, хамаг амьтны зүгээс баясал хүндлэлийг олмуу.” (Цагаан Лянхуа Судрын сургаалыг шүтэгч хүний сэтгэл санаа ариун байдаг тул олон зүйлийг хийж чадахг ба төөрөгдөл нь бүрэн арилаагүй байсан ч гэлээ сэтгэлийн дээд түвшинд амар амгалан оршиж, олон хүнд хүндлэгдэн дээдлэгдэх болно.)

“Ном номлогчийн эрдэм буяныг өгүүлэх бүлэг”-ийн энэхүү нэг мөр дээр өгүүлсэн зүйлүүдийг тодорхой илэрхийлж байна. Дээр нь энд бурхантай ярилцаж буй хүн бол Ашид Хичээнгүй Бодисадва юм. Үүнийг би өөрийнхөөрөө тайлбарлах юм бол, Шагжамүни бурхан бидэнд “Хэзээ ч, хаана ч, ямар ч хүнтэй учирсан энэрэнгүй, халуун дулаан сэтгэлээр хандахаа мартдаггүй бодисадва байгаарай.” хэмээн урам зориг хайрласан гэж бодож байна.

Жилийн эцэст айл болгон их цэвэрлэгээ хийдэг шиг, цэвэр шинэлэг сэтгэлээр шинэ оноо угтахын төлөө хүмүүс бид ч гэсэн сэтгэлийнхээ тортгийг гөвөх хэрэгтэй биз ээ. Энэ нэг жилийг эргэн харахад танд Бурханы ямар урмын үг сонсогдож байна вэ?

«Косей» 2020 оны 12 дугаар сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Ашид Үл Басагч Бодьсадваг өгүүлэх 20 дугаар бүлэг

Бурханлаг чанарт мөргөх ганцхан үйл

Хүний аз жаргалгүй байдлын эх үндэс бол “Махан биеэ өөрийн бие.” хэмээн буруу боддогт байгаа юм. Энэхэн махан биеийг ороох зүйл их байх тусам төдий чинээ юу юунаас илүү өөрийн махан биеийг л бодсондоо сэтгэл ханамж өгөх зүйлийг нэгдүгээрт тавьж, бусдыг хоёрдугаарт тавьснаар эцэстээ хоорондоо тэмцэлдэж дайсагнан сэтгэл зовнил, шаналал, зовлон зүдгүүр тасардаггүй.

Тиймээс хүмүүсийг үндсээр нь аварч, хүний нийгмийг үнэхээр энх тайван болгохын тулд яах ч аргагүй энэ үндсэн буруу бодлыг үгүй хийж, “Хүний үндсэн мөн чанар бол бурханлаг чанар юм.” гэсэн жинхэнэ үнэнийг ухааруулах шаардлагатай. Өдөр тутамд сэтгэл хийгээд үйлдлээ ямар байлгах талаар муу зүйл хийхгүй, сайн зүйл хийх хэрэгтэй гэж нэг бүрчлэн заах нь хүнийг сайн сайханд хүргэх чухал арга хэдий ч ганцхан энэ аргаар тэр болгон үр дүн гарахгүй. Хүний үндсэн мөн чанар болох “Бурханлаг чанар” хэмээх жинхэнэ үнэнг ухаарах юм бол аяндаа муу зүйл хийж чадахгүй болдог. Олиггүй муухай, ичгүүртэй санагдаж хийж зүрхлэхгүй.

Мөн бусад олон хүний тухайд ч бүгд Бурханы ачаар амьдарч буйгаа, бурханлаг чанарыг агуулсан бодгал хэмээх байгалийн зохилдолгоог ухаарах аваас бид бүгд ах дүүс гэсэн мэдрэмж оргилон гарах ирдэг учраас үнэхээр халуун дотно болж чадах учиртай.

Тиймээс уг бүлэгт эрт дээр үед Ашид Үл Басагч Бодисадва хэмээх хүн байсан бөгөөд “Хүний бурханлаг чанарыг шүтэх” хэмээх цор ганц үйлийг үргэлж хийснийхээ үр дүнд өөрөө ч бурханы гэгээрлийг олж, олон хүнийг ч гэгээрлийн зам мөрд нь оруулсан тухай айлдсан учиртай.

Тэрхүү Ашид Үл Басагч Бодисадва бол хүн харахаараа л “Би таныг дорд үзэж байгаа хэрэг биш шүү. Та бол гарцаагүй бурхан болж чадах хүн.” хэмээгээд залбирдаг байжээ. “Бурхан болж чадах” гэдэг нь өөрөөр хэлбэл “Бурханлаг чанартай” гэснээс өөрцгүй ба жирийн хүмүүс тэр утгыг нь ойлголгүй, тохуурхаж байна хэмээн бухимдаж, чулуу шидэн, саваа модоор чичилдэг байжээ. Тэгсэн ч гэсэн Ашид Үл Басагч Бодисадва гүйн зугтах боловч холоос аанай л тэдгээр хүмүүст залбирч, “Та нар бол бурхан болж чадах хүмүүс билээ.” хэмээн хашгирдаг байж.

Ердөө тийм ганцхан үйлийг цөхрөлтгүйгээр хийснийхээ ачаар Ашид Үл Басагч Бодисадва насан эцэслэх мөчөө ирэхэд Цагаан Лянхуан Судрын сургаалыг нэгд нэгэнгүй айлдаж чадсанаар үхэшгүй мөнхийн бурханлаг чанарыг өөрийн биеэр мэдэрч чадсан. Тэгээд хэдэнтээ энэ



ертөнцөд төрөн, тэрхүү жинхэнэ үнэний сургаалаа айлдсаар, эцэстээ Бурханы чинээнд хүрдэг.

Энэ ярианы дараа Ашид Үл Басагч Бодисадва гэдэг нь үнэндээ Шагжамүни бурханы өмнөх төрөл байсан нь тодорхой болдог. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан ч бүх хүнд бурханлаг чанар байдгийг гэгээрч, түүнийг нь нээхийн төлөө хичээн зүтгэж чадсан учраас л бурханы гэгээрлийг олж чадсан учиртай.

Сургаалыг айлдах ч гэсэн чухал

Тэрхүү Ашид Үл Басагч Бодисадвагийн үйл гэдэг нь эхэндээ зүгээр л “Хүмүүсийн бурханлаг чанарт залбирах” үйл байсан бол хүмүүс арай гэж өөрийн бурханлаг чанарыг ухаараад ирэхээр бурханлаг чанарын талаар сургаал айлддаг байжээ. Эндээс бид бүхэн ч гэсэн суралцах хэрэгтэй. Юун түүрүүнд “Бүх хүний бурханлаг чанарыг хүлээн зөвшөөрч, түүнд залбирах”-аас эхлээд “Жинхэнэ үнэний сургаал болох Цагаан Лянхуа Судрыг айлдаж, хамаг амьтны бурханлаг чанарыг нээх.” гэсэн дарааллаар явах хэрэгтэй. Тийм идэвх чармайлттайгаар хичээн зүтгэж байж л өөрөө ч гэгээрлийг олж, хорвоо ертөнц ч үнэхээр сайхан болох болно.

Тууштай хичээл зүтгэл

Тийнхүү хичээн зүтгэхдээ ч гэсэн Ашид Үл Басагч Бодисадва мэт хэзээ ч хувирашгүй итгэл үнэмшилтэй байж, тэвчээртэй, тууштай байх ёстой юм. Жаахан хийж үзчихээд санасан үр дүн гарахгүй болохоор шууд шантарч, бодит ертөнцийн дэндүү хатууд сэтгэлээр унахдаа хаяаад явчих юм бол өөрөө ч, хорвоо ертөнц ч эцсийн бүлэгт аврагдахгүй билээ.

Хүний бурханлаг чанар үхэшгүй мөнх учир “Хэдэн ч удаа дахин төрж, үхэх хооронд эцсээ хүртэл энэ агуу ажлыг үргэлжүүлэх.” гэсэн хувирашгүй сэтгэлтэй байх ёстой. Энэ утгаараа Ашид Үл Басагч Бодисадва бол эрхэм нандин үлгэр жишээ болохыг хэлэхгүй өнгөрч боломгүй.



Олон улсын хэлтсийн даргын булан

Ирэх жил Ашид Хичээнгүй бодьсадва болцгооё !

Саитоо Кооичи

12 сартай золголоо. Хуанлигаар бол жилийн сүүлийн сар боловч Рисшо Косей Кай байгууллагын хувьд шинэ жилийн эхний сар билээ.

Нивано ерөнхийлөгч “Өдөр бүрийг өөдрөг шинэлэг өнгөрүүлэх” гэсэн энэ сарын сургаалаараа өнгөрсөн нэг жилийг дүгнэж, ирэх жил ямар сэтгэлтэй байх талаар айлдан чиглүүлсэн.

Корона цар тахлын үе ч гэсэн нөхцөл байдал, эргэн тойрондоо автагдалгүй “Энэ газар бол зам мөрийн газар болой” гэсэн сэтгэлээр үргэлж бусдын төлөө бодож хүмүүстэй харилцах чухал гэдгийг сануулсан.

Тухайлбал хэзээ ч, хаана ч, ямар ч хүнтэй учирсан энэрэнгүй сэтгэлээ марталгүй бодьсадвагийн үйлд шамдах хэрэгтэй хэмээн айлдсан.

Миний тухайд энэ сараас Токио Ниши сургаал дэлгэрүүлэх хэсгийн дарга, Оота салбарын тэргүүнээр ажиллах үүрэг авч Олон улсын хэлтсийн даргын үүргээс буухаар болсон.

Шинэ аялал эхэлж байгаатай холбогдуулан би ч гэсэн үргэлж энэрэнгүй сэтгэлээ марталгүй, учирсан хүндээ баяр баяслыг бэлэглэхийг хичээж, бурхны үйлд шамдах болно.

Цаашид Акагава Кэйичи шинэ даргатай хамтран дэлхий дахинд сургаал номыг улам дэлгэр түгээгээрэй хэмээн хүсэн залбирч байна. 3 жилийн турш тусалж дэмжиж байсан та бүхэндээ баярлалаа. Гүнээ хүндэтгэн мөргөө.




Баруун талд Саитоо, зүүн талд Акагава



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: kosekaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/RKUnitedKingdom>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>